

ХЭСЭГЧИЛСЭН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь
					Хагас жил		
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
1	Зорилго 1. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.						
1.1	6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.						
	НЗДҮАХ-ийн 6.1.9, НЗДТЖҮЧ-ийн 9.8. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана.						
1.1.1	1.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг шат дараатай зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэх эрх олгоно.	-	Төсөл хэрэгжүүлэлтийн сонгон шалгаруулалтын тоо	4	2	Сүхбаатар дүүргийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах СБД-11, СБД-12 багцын төслийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж газрын даргаар батлуулсан. Сонгон шалгаруулалтын 16 багцын баримт бичгийг аж, ахуйн нэгжид цахим хаягаар хүргүүлж ажилласан. Үнэлгээний хороо 1 удаа хуралдаж ХУД-09 багцад “Нутгийн буян групп” ХХК шалгарсан. 2022 оны байдлаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнтэй холбоотой ажлын хэсгийн хурал удаашралтай байна. Цаашид зорилтот төвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Холбогдох төслийн хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, зөрчлийг арилгах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байр, Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ХАА-27 дугаар байр, Сүхбаатар дүүрэг 10 дугаар хороо хорооны нутаг дэвсгэр дэх 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр зэрэг ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн	80%

						<p>зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах, орон сууцыг орон сууцаар солих замаар чөлөөлөх, чөлөөлсөн талбайд түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулан ажиллахыг “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-д шилжүүлэх санал бүхий захирамжийн төсөл, танилцуулгыг бэлтгэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/498 дугаар захирамжаар батлагдсан. Захирамжийн дагуу багцуудын мэдээллийг гаргаж нийслэлийн Орон сууцны корпораци ХК-д хүргүүлсэн.</p> <p>Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 53 дугаар байрыг буулган шинэчлэн барилгажуулах эрх олгогдсон “Элит констракшн” ХХК, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 21, 22 дугаар байрыг буулан шинээр барих төсөл хэрэгжүүлэгч “Уран проект” ХХК, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 30 дугаар байрыг буулган шинэчлэн барилгажуулах эрх олгогдсон “Вишн девелопмент” ХХК, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны нэхмэлийн 3, 4, 8, 9 дүгээр байрыг буулан шинээр барих төсөл хэрэгжүүлэгч “Эм жи капитал” ХХК-ийн танилцуулгыг бэлтгэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулж ажилласан.</p>	
1.1.2	1.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулж орон сууцыг ашиглалтад оруулна.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруултаар	Ашиглалтад оруулсан барилгын өрхийн тоо	2,478	2,538	Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт төсөл хэрэгжүүлэгчээр ажиллаж байгаа “Металл энд Вүүд” ХХК-ийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны Төмөр замын 5 дугаар байрыг буулгаж, 137 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг ашиглалтад хүлээн авах “Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисс”-т орж ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр комиссийн актыг баталгаажуулсан болно.	100%
1.1.3	1.3 Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх.	-	Саналын тоо	2	1	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинэчлэн барилгажуулах ажлын явцын танилцуулга, цаашид боловсруулах шаардлагатай төсөл, төлөвлөгөө, зураг төслийн ажлын танилцуулга, шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоог бэлтгэн Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралд танилцуулан ажиллав. Хурлын тэмдэглэлд хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх үүргийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт даалгасан бөгөөд манай газраас төсвийн хөрөнгө хүсэх	100%

						тухай албан бичгийг холбогдох тооцооны хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн болно. Төсвийн хөрөнгө шийвлэрлэгдсэний дараа 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгч ажиллана.	
ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД							
<i>Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:</i>							
2.1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтаар баталсан аргачлал, загварын дагуу “Алсын хараа”, эрхэм зорилго, стратегийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн бүхий “Байгууллагын стратеги төлөвлөгөө 2021-2024”-ний төслийг нэгтгэн боловсруулж Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн чиг үүрэгт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг тухай бүр тайлагнаж ажиллаж байна.	100%
<i>Барилга, хот байгуулалтын үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:</i>							
2.2	1.5 Нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрт барилга, байгууламж барих хүсэлтийг хүлээн авч холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрт барилга байгууламж барих зөвшөөрөл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг нэг цэг, төрийн цахим үйлчилгээгээр нийт 214 барилга барих хүсэлтийг хүлээн авч судлан, Мэргэжлийн зөвлөлийн 19 удаагийн хурлаар хэлэлцүүлж, 111 архитектур төлөвлөлтийн даалгавар батлаж хүргүүлсэн.	100%
2.3	Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байршуулах ажлыг зохион байгуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 360 дугаар “Нийслэлийн засаг даргын тамгын газар, улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газар, улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” тогтоолын дагуу хийгдсэн Нийслэлийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр тус чиг үүрэг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд шилжсэн. Тайлант хугацаанд хөшөө байгуулах талаар 1 хүсэлт ирүүлснийг Захирагчийн ажлын албанд шилжүүлсэн.	100%
2.4	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, Барилга, байгууламжийн загвар зураг батлах,		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн гэр хорооллын нутаг дэвсгэрт иргэн аж ахуй нэгжээс ирүүлсэн 10 эх зургийг зөвшилцөж, хянан батлуулсан байна.	100%

	хүчинтэй хугацааг шийдвэрлэх.						
2.5	1.4 Хот байгуулалтын баримт бичгийн зургийн даалгавар боловсруулах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дүгээр сарын 31 -ний өдрийн 08/22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон сууцны 7 дугаар нэгж хорооллын"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн К1,Е1,3 хэсэгчилсэн талбайн ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн ерөнхий архитектороор хянан батлуулж Орон сууцны бодлогын газарт хүргүүлсэн болно.	100%
2.6	1.6 Ашиглалтын шаардлага хангахгүй барилга, гэр хорооллын нутаг дэвсгэрт Барилга, байгууламжийн загвар зураг /эскиз/ батлах, хүчинтэй хугацааг сунгах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган барилгажуулах төслийн хүрээнд дараах төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаас хэлэлцүүлж, нийт 11 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, эх загвар зургийг баталж хүргүүлсэн. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаас хэлэлцүүлж, 5 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, эх загвар зургийг баталж хүргүүлсэн.	100%
2.7	1.7 Барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийг шийдвэрлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Барилгын байгууламжийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх 5 хүсэлтийг Нийслэлийн ерөнхий архитекторт тухай бүрт танилцуулан, шийдвэрлэсэн байна.	100%
<i>Хот дахин хөгжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:</i>							
2.8	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж,		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган заасан хугацаанд тайлагнан ажилласан.	100%

	шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах						
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:							
3.1	3.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> - Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын биелэлт - Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлт - Үндэсний аюулгүй байдлын Зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн биелэлт - НЗД-ийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр - НЭЗ нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт; - НИТХ, НИТХТ-ийн тогтоол, хурлын тэмдэглэл; - Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар; - Нийслэлийн удирдах ажилчдын шуурхай; - Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврын биелэлт; - Нэгжийн 14 хоног, сар, улирлын тайланг цаг хугацаанд нь гаргаж Захиргаа санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. 	100%
3.2	3.2.Нэгжийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хэлтсийн чиг үүргийн дагуу болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлт, гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой асуудлаар 150 орчим иргэнд мэдээ мэдээлэл өгч ажилласан.	100%
3.3	3.3.Нэгжийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих ажлыг гүйцэтгэх эрх бүхий аж ахуй нэгж байгууллагыг сонгох сонгон шалгаруулалтыг нийт 31 багц мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тутмын Өдрийн сонин, http://ulaanbaatar.mn/ , байгууллагын веб хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй зарласан. 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатар НЗДТГ-ын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав” салбарт иргэдтэй уулзах уулзалтад танилцуулга бэлтгэн оролцов. “Дахин төлөвлөн барилгажуулах, дэд бүтэцжүүлэх төслүүд” улсын анхдугаар зөвлөгөөн 2022 оны 04 дүгээр сарын 01-ний	100%

						<p>өдөр Эрдэнэт хотод зохион байгуулагдаж хэлтсийн 5 мэргэжилтэн оролцож дахин төлөвлөлт, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих төслийн талаар танилцуулга, мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай буулган дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч "Хур алтан өргөө" ХХК, "Монтекарло голд" ХХК нартай албан уулзалт хийж, холбогдох мэдээ мэдээллээр ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/515 дугаар захирамжаар төсөл хэрэгжүүлэх эрх олгогдсон "Монтед констракшн" ХХК, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Үйлдвэр хоршооллын 12 дугаар байрны оршин суугчидтай хамтарсан уулзалтыг зохион байгуулан ажиллав.</p>		
3.4	3.7.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийн хэрэгжилтийг ханган тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>2022 оныг Нийслэлийн хэмжээнд "Хотын иргэний жил" болгон зарлах танилцуулга бэлтгэх ажилд хамтран ажилласан. Одоогоор хэлтсийн хэмжээнд иргэний эрүүл мэндийн үзлэг оншилгоо, эрт илрүүлэлт явуулах ач холбогдол бүхий байршлуудыг 3 төрлийн 363 цэгийн байршлын судалгааг боловсруулж байна.</p>	70%	
3.5	Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах	-	Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/	1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг дунджаар 60 цаг	1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг дунджаар 40 цагаас багагүй байх	<p>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/59 дугаар захирамжаар баталсан хуваарийн дагуу Нийслэлийн хэмжээнд томоохон хэмжээний гамшиг, осол, аюулт үзэгдэл болсон үед орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах чиг үүрэг бүхий Түр орон байраар хангах албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд хийсэн Нийслэлийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалтад оролцсон.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног болгоны Пүрэв гаригт явуулдаг 7:4:10 арга зүйн цахим сургалтад хамрагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Улсын их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны талаар" - Орчин үеийн хөгжлийн мегатрендүүд" - "Албан ёсны статистик ба их өгөгдөл" - "Аз жаргалтай ажиллахын нууц "монгол орны хэтийн төлөв" - "Манлайллын хэв маяг, хандлагаа тодорхойлох нь" - "Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь" - "Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил" - "Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх ба ялгаварлан гадуурхлаас ангид байх" 	100%	
3.6	Архив, албан	Албан бичгийг	-	Үйл ажиллагааны	100	100	Тайлант хугацаанд нийт 282 албан бичиг хүлээн авч хугацаандаа шийдвэрлэсэн 132 албан бичгийг шийдвэрлэсэн. Хариугүй албан	100%

	хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг чанаржуулах		хэрэгжилт, гүйцэтгэлээр			бичиг 142. Албан бичгийн шийдвэрлэлтийн дандаж хугацаа 12.2 хоног байна.	
		Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах -Ирсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хэвлэх, цахимаар ирсэн бичгийг бүртгэл хяналтын картын хамт EDOC системээс хэвлэн, архивлах (үндсэн үйл ажиллагааны чиглэлээр)		Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр	Үгүй	Тийм	Хуулийн этгээдээс 4 эх үүсвэрээс барилга барих хүсэлт, албан бичиг, өргөдөл, гомдол ирүүлснийг бүртгэн бүртгэл хяналтын картаар албан хаагчдад шилжүүлэн ажиллав. Нэгжийн хэмжээнд албан бичиг, өргөдөл, барилга барих хүсэлт, загвар зургийн бүртгэлийг тоон болон бүртгэл хяналтын дэвтэр хөтлөн ажиллаж байна. Тайлант хугацаа бүрт мэдээллийг нэгтгэн тайлагнаж ажиллав.	100%
3.7	Өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх		Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	8 хоног	Тайланд хугацаанд нийт 211 өргөдөл, гомдол ирүүлснээс 191 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаандаа байгаа өргөдөл, гомдол 20. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 19 цаг байна.	90%

3.8	3.16. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу Захиргаа санхүүгийн хэлтэст архивын баримт бичгийг хүлээлгэн өгсөн.	100%
<u>ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД</u>							
4	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.						
4.1	Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах	-	I-UP мэдээллийн цонхонд мэдээ мэдээлэл байршуулсан тоо	1	2	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинэчлэн барилгажуулах ажлын явцын танилцуулга, тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулга бэлтгэсэн.	100%

Төлөвлөгөөг үнэлсэн:

Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга

(албан тушаал)

Төсвийн Шууд захирагч

..... / ***Ц.Тулга*** /

(гарын үсэг)

..... *(огноо)*

Тайлагнасан:

Хэсэгчилсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга

(албан тушаал)

Нэгжийн дарга

..... / ***М.Мэндсайхан*** /

(гарын үсэг)

..... *(огноо)*